



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/47/

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29-дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа Геодезийн цэг тэмдэгтийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Жаргалсайхан -Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Баярсүх -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Г.Ганзориг -Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

- Сумдын Засаг дарга

- Сумдын газрын даамал

Нарийн бичгийн дарга:

Б.Төгөлдөр -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Геодези зураг зүйн мэргэжилтэн


2. Геодезийн цэг тэмдэгтийн үзлэг тооллогыг шуурхай зохион байгуулж, дүнг нэгтгэн Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлэхийг ажлын хэсэг /Т.Жаргалсайхан/-т үүрэг болгосугай.

02 02327

2.

3.Хууль тогтоомжийн хүрээнд нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн байнгын цэг тэмдэгтийг тоолох, хадгалах, хамгаалах, сэргээн босгох ажилд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэн, ажлыг үр дүнтэй зохион байгуулж тайлагнахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

